



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/48

Есөнбулаг

Эрх шилжүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн "Аймгийн 2024 оны төсөв батлах тухай" 71 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Дэлгэр сумд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хавсралтаар баталж, гүйцэтгүүлэх эрхийг Дэлгэр сумын Засаг дарга (Д.Чинзориг)-д шилжүүлсүгэй.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж шаардлага хангасан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Дэлгэр сумын Засаг дарга (Д.Чинзориг)-д үүрэг болгосугай.

3. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ



Аймгийн Засаг даргын 2024 оны  
1 дүгээр сарын 11-ны өдрийн 48 дугаар  
захирамжийн хавсралт

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР 2024 ОНД  
САНХҮҮЖИХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Хугацаа		Төсөвт өртөг (төгрөг)
		Эхлэх	Дуусах	
1.	Дэлгэр сумын Баянхонгор багийн төвийн барилгын засвар	2024 он	2024 он	15,000,000
2.	Дэлгэр сумын Цэцэрлэгийн гадна талбайн тохижилт	2024 он	2024 он	10,000,000
3.	Дэлгэр сумын Баянбуурал багийн төвийн барилгын засвар	2024 он	2024 он	10,000,000

\_\_оОо\_\_